



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө залруулан бүртгэх
Зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй, нийт 654,080,000.00 (зургаан зуун тавин дөрвөн сая наян мянга) төгрөгийн балансын үнэ, 5110 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг хэмжилтийн зөрүүний 4 м.кв талбайгаар хорогдуулж, 5106 м.кв болгож, үнэлгээг 653,568,000.00 (зургаан зуун тавин гурван сая таван зуун жаран найман мянга) төгрөгөөр залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Ж.Золзаяад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг залруулан бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133000386
6-r huraldaan.docx